

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-18
<hr/>	
1. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP17)-ын бэлтгэл ажлын талаар мэдээлэл сонсох	4-18
<hr/>	

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны
4 дүгээр сарын 14-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны дарга Б.Уянга ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 8 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 35 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Г.Лувсанжамц, Б.Найдалаа, С.Цэнгүүн.

Нэг.Нэгдсэн Үндэсний Байгууллагын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP17)-ын бэлтгэл ажлын талаар мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бат-Өлзий, Байгалийн нөөц, зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, COP17 бага хурлыг зохион байгуулах ажлын албаны дарга Д.Батмөнх, мөн албаны Үйл ажиллагаа, логистик, аюулгүй байдлын газрын дарга Н.Өнөр, багийн ахлагч Ж.Санчир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт М.Мандхай байлцав.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP17)-ын бэлтгэл ажлын талаарх мэдээллийг COP17 бага хурлыг зохион байгуулах ажлын албаны Үйл ажиллагаа, логистик, аюулгүй байдлын газрын дарга Н.Өнөр, мөн албаны багийн ахлагч Ж.Санчир нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа, Б.Пунсалмаа, Б.Уянга нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бат-Өлзий, Байгалийн нөөц, зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, COP17 бага хурлыг зохион байгуулах ажлын албаны Үйл ажиллагаа, логистик, аюулгүй байдлын газрын дарга Н.Өнөр, мөн албаны багийн ахлагч Ж.Санчир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP17)-ын бэлтгэл ажлын талаарх мэдээллийг сонсов.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 53 минут үргэлжилж, 8 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 14 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ЗОРИЛГЫН ДЭД ХОРООНЫ
ДАРГА

Б.УЯНГА

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
13 цаг 35 минут.

ТОГТВРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Уянга: Өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 14-ний өдрийн Эдийн засгийн байнгын хорооны Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны хуралдаан эхэлж байна. Дэд хорооны хуралдаанд хүрэлцэн ирсэн эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя. Батжаргалын Заяабал гишүүн, Мэндбаярын Мандхай гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн, Агваанлуvsангийн Ундраа гишүүн, Болдын Уянга гишүүн бид өнөөдөр хурлаа эхлүүлж байна. Чөлөөтэй байгаа гишүүд Лувсанжамц гишүүн, Найдалаа сайд, Цэнгүүн гишүүд байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, дэд хорооны ирц 62,5 хувьтай бүрдсэн тул Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны 2026 оны 4 сарын 14 өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал буюу COP17-ийн бэлтгэл ажил болон хүлээгдэж буй үр дүнтэй холбоотой мэдээлэл сонсоно.

Тэгэхдээ бэлтгэл ажил болон өөр бусад логистикийн асуудлуудыг өчигдөр бас танайх хуралдаанаараа зохион байгуулсан. Тэр мэдээлэл бас нээлттэй хүргэгдсэн учраас өнөөдрийн энэ Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны хуралдаанаар хүлээгдэж байгаа үр дүнтэй холбоотой асуудлыг голчлон бүгдээрээ ярилцъя. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд ямар зохион байгуулалттай оролцох вэ, хэрхэн дэмжих вэ гэдэг дээр бас асуудлаа нээлттэй хэлэлцүүлээд өгөөрэй. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орёе.

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурлын хүлээгдэж буй үр дүнтэй холбоотой мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Тэгэхээр өнөөдөр хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны холбогдох газрын дарга нар мөн COP17 бага хурлыг зохион байгуулах ажлын албанаас бас хүмүүс ирсэн байгаа. Тэгэхээр эхний мэдээллийг Жаргалсайханы Санчир COP17 бага хурлын зохион байгуулах ажлын албаны Бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын багийн ахлагчаар ажиллаж байгаа Санчир танилцуулах юм байна. Микрофоныг нээхийг хүсье.

Ер нь бол ажлын хэсгээ танилцуулах ёстой юм байна. Тэгэхдээ мэдээллийн дараа танилцуулъя.

Ж.Санчир: Сайн байцгаана уу. Энэ өдрийн мэндийг хүргэе та бүхэнд. Энэ удаагийн COP17 хурал маань дараах уриатай нэгдсэн уриан дор явагдаж байгаа. Их байгалиа сэргээе, итгэл найдвараа бадраая гэдэг.

Тэгэхээр COP17 гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Энэ бол НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын аага хурал гэдэг утгаараа цөлжилт, газар, газрын доройтол гэсэн үндсэн асуудлын хүрээнд сэдэв нь хөндөгдөж ингэж явдаг хурал байгаа. Тэгэхээр манай уриа саяын дурдсан шиг газартай холбоотой. Газар гэдэг бол амьдралын эх үүсвэр, газар гэдэг бол устай салшгүй холбоотой, амин холбоотой гэдэг үүднээс ийм дараах 6 тэргүүлэх урианы дор явагдаж байгаа.

Их байгалиа сэргээе, эдийн засгаа сайжруулъя, тэсвэрлэх чадвараа нэмэгдүүлъя, усны нөөцийг хамгаалъя, амьдралыг тэтгэе, эрүүл энхийг эрхэмлэе, өв соёлоо хадгалъя гэдэг 6 дэд уриа доор явагдаж байгаа гэж ойлгож болно.

Газар, газрын доройтол цөлжилттэй холбоотой асуудал яригдах болгонд нөхөн сэргээлт буюу газрын рестрэйшний асуудал заавал яригддаг. Тэгэхээр энэ дэлхийн хэмжээний НҮБ-ын конвенцын хурал учир мэдээж газар гэдэг асуудал цөм болж орж ирж байгаа. Тэгэхээр дэлхийн газар нутгийн болон бэлчээрийн холбогдолтой статистикийн бодит байдлыг халти танилцуулаад явчихъя.

Тэгэхээр энэ бол хурлын үеэр яригдаад явах маш ач холбогдолтой тоо гэж үзэж байгаа. Дэлхий дээрх газар нутгийн 40 орчим хувь доройтож, биологийн олон янзын байдал, амьжиргаа, уур амьсгалын өөрчлөлтөд нэн сөргөөр нөлөөлж байна.

2030 он гэхэд 1 тэрбум га газар доройтсон. Нөхөн сэргээх зорилттой байгаа. Одоогийн байдлаар 150 сая га газар доройтсон гэж үзэж байгаа. Албан ёсны статистикаар. Тэгэхээр 150 сая газрыг нөхөн сэргээснээр 200 сая хүний хүнсний аюулгүй байдлыг сайжруулах тодорхой хэмжээнд шийдэх боломж үүсдэг гэдэг тоо явдаг. Нөхөн сэргээлтэд оруулсан 1 ам.доллар бүрийн хөрөнгө оруулалтад 7-30 ам.долларын үр өгөөжийг бий болгодог гэж ерөнхийдөө үздэг учраас яагаад энэ хурал чухал вэ гэдгийг энэ статистикууд онцолж харуулж байгаа гэж бодож байгаа.

Энэ удаагийн Улаанбаатарт зохиогдох хурал маань анхны тоогоор багцаагаар нийт 10 мянга орчим оролцогчдыг татаж оролцуулах ийм төлөвтэй ерөнхийдөө явж байсан. Одоогийн байдлаар энэ дэлхий даяар үүсээд байгаа нөхцөл байдал,, геополитик, бусад улс орны хоорондын асуудлуудтай холбоотойгоор мэдээж багасгаж орж ирэх байх гэсэн төсөөлөлтэй ажиллаж байгаа. Тавигдаж буй 2 дахь том үр дүн бол олон улсын дэвшүүлж буй газарт суурилсан шийдлүүдийг ахиулах, зоримог, хэрэгжихүйц санхүүжилт татах боломжтой шийдлүүдийг энэ удаагийн хурал дээр нэн чухал тавьж шийдэхийг зорьж байгаа хурал гэж хэлж болно.

Хурлын өөр нэг стратегийн үр дүн, хүлээгдэж буй үр дүн бол UNCCD буюу Цөлжилттэй тэмцэх конвенцын дараагийн циклийн барих стратегийн баримт бичиг дээр тодорхой хэмжээнд ажиллах, ган цөлжилтийн асуудал, түүний санхүүжилтийн дутагдлыг нөхөх чиглэлээр харилцан тохиролцсон шийдвэрүүд гаргахыг талууд зорьж байгаа гэж ойлгож болно.

Монгол Улсын хэмжээнд гэвэл Монгол Улсаас тал хээрийн төлөвлөгөө гэсэн нэгдсэн 1 малгай доорх санаачилга дэвшүүлээд явж байгаа. Одоогоор зорьж буй үр дүн бол мөнгөн болон мөнгөн бус амлалт, бусад санхүүжилтийн боломжийг 1 тэрбум ам.доллар гэсэн зорилт тавьчихсан төсөөлөөд ажиллаж байгаа гэж хэлж болно.

Миний сая дурдсан яг шууд Монгол Улстай холбогдох Монгол Улсын манлайлаад, тэргүүлээд явж байгаа санаачилгыг бид нар “Тал хээрийн төлөвлөгөө”

гэж нэрлээд хурлын үеэр албан ёсоор нээж, олон улсын хамтрагч талууддаа танилцуулах зорилготой ажиллаж байгаа. Тал хээрийн төлөвлөгөө гэдэг малгай санаачилга маань улс төрийн санхүүгийн болон бусад амлалтуудыг урт хугацааны бодит үр дүн, бодлого, бодлогын өв буюу легасыг бүрдүүлж цааш нь авч явах гэдэг ийм үндсэн зорилго дэвшүүлж байгаа. Энэ доор юу яригдах вэ гэвэл мэдээж Рио-ийн буюу уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой биологийн олон төрөл янзтай холбоотой. Мөн Цөлжилтийн конвенцын уялдаа холбоог хангах хэрэгжилтийг уялдуулах механизмыг боловсруулах, сайжруулах. Түрүүн би дурдаад өнгөрсөн салангид байдаг олон төслүүдийг нэг цогц арга хэмжээний төлөвлөгөө болон боловсруулах мөн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг санхүүжүүлэхэд хөрөнгө оруулалтын багц бий болгох гэсэн төслийн хэллэгээр бол pipeline хийхээр зориод явж байгаа гэж хэлж болно.

Та бүхэндээ товчхон тал хээрийн төлөвлөгөө дотор орж би 3 тэргүүлэх санаачилгыг танилцуулъя. Бэлчээрийн тэргүүлэх санаачилга буюу RFI бол Монгол Улсын UNCCD-тэй хамтран боловсруулж буй Монгол Улсын тэргүүлсэн тэгэхдээ олон улсын санаачилга гэж ойлгож бол болно. Тэгэхлээр энэ хүрээнд хуурай гандуу бүс нутгийн тогтвортой бэлчээрийн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй газар ашиглалт зэрэг асуудлууд бол нэн тэргүүнд хөндөгдөх юм байгаа юм.

Дараагийн 2 санаачилга буюу Ус ба газрын нэгдсэн менежмент, байгальд суурилсан шийдэл бүхий дэд бүтцийн 2 санаачилга бол бас Монголын хамтран дэвшүүлж буй олон улсын санаачилга. Тэгэхдээ эхнийхээсээ өөр юм нь гэвэл албан ёсны шийдвэр буюу UNCCD-ийн шийдвэр гарахгүй. Бусад байдлаар дэмжигдээд явах боломжтой санаачилга гэж үзээд тэргүүлэх 3 санаачилгынхаа эгнээн доор багтаасан байгаа.

Энийг нэг их задалж ярихгүйгээр шууд тогтвортой хөгжлийнхөө зорилгуудтай шууд уяад яриад явчихъя. Та бүхэн дараа нь тодруулах байвал тодруулаарай. Би боломжийнхоо хэрээр хариулаад явна.

Бэлчээрийн тэргүүлэх санаачилга буюу миний түрүүний дурдсан RFI санаачилга бол үндсэн чиг чиглэлээрээ SDG 15, 17-той шууд холбогдоод уялдаад явж байгаа. Тэгэхээр мэдээж индикатораар нь тооцоод үзвэл 15 дээр бууж байгаа. 15.2,1, 15.5.1 15.3 гэхчлэн тогтвортой менежмент ба доройтсон газар сэргээх арга хэмжээ, биологийн олон янз байдлын индексийн өөрчлөлтүүд, цөлжилттэй тэмцэх газрын доройтлыг шийдэх хөрсийг нөхөн сэргээх зэрэг арга хэмжээнүүд багтсан. Индикатортай 15, 17 гэсэн үндсэн тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдаад явж байгаа.

Манай 2 дахь тэргүүлэх санаачилга буюу Ус газрын нэгдсэн менежмент гэдэг санаачилга бол SDG-ийн 6 болон 15-тай шууд уялдаад явж байгаа. 6 бол мэдээж ойлгомжтой устай холбоотой тогтвортой хөгжлийн зорилго байдаг. Энэ бол усны нөөцийг тогтвортой ашиглах, ус, газрын нэгдсэн менежментийг нэвтрүүлэх, усны хомсдолыг бууруулах, усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх гэсэн үндсэн индикаторуудтай нийцээд явж байгаа.

Манай 3 дахь тэргүүлэх санаачилга буюу тогтвортой дэд бүтцийн байгальд суурилсан шийдэл гэхээр бас хүмүүст жоохон ойлгомжгүй бууж байж магадгүй. Байгальд суурилсан шийдэл гэдэг ерөнхий утгаар нь ойлгох юм бол ногоон, байгальд ээлтэй ямар л шийдэл байна, тэр механизм байна. Тэрийг эхний 2

санаачилгаар шийдэх боломжтой илүү суурь механизм байдлаар орж ирж байгаа. Тэгэхээр энэ болохоор олон улсын хөрөнгө оруулагчдад танилцуулах төслийн санаа, санаачилгыг илүү цааш нь дэлгэрүүлж төслийн цогц концепц pipeline болгож бэлтгэх гэдэг дээр илүү манай 3 улсад тэргүүлэх санаачилга дээр орох илүү орц гадаад боломжит түншүүдийг татах сонирхлыг нь төрүүлэх гарц гэж бид нар бол харж байгаа. Тэгэхээр энэ бол SDG 9 13 зэрэгтэй холбогдоод явж байгаа. Уур амьсгалын өөрчлөлт, ус тогтвортой, найдвартай, уян хатан дэд бүтэц, тэгээд цаашлаад ярих юм бол мэдээж ядуурал, газар дээрх бүх амь амьдралын асуудлууд, уур амьсгалын өөрчлөлт гээд асуудлуудтай нь бүгдээрээ мэдээж холбогдоод явж байгаа.

Түрүүн зохион байгуулалтын UNCCD COP17-ийн зохион байгуулалтын нэгдсэн үр дүн төсөөллийг танилцуулсан бол энэ илүү манай энэ удаагийн дага хурал ямар онцлогтой болж байгаагийн талаарх нэг слайд байгаа. Мэдээж хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл буюу SDG 12-той нийцэхийн тулд хуванцаргүй байлгах. Хуванцар байлаа гэхэд хуванцрын хэрэглээг арай бага байлгах, шийдвэр гаргах буюу шийдвэр гаргалтаас өмнөх бүх арга хэмжээ, дэд хороодын хурал, ажлын хэсгүүдийн хурал зэрэгт хүмүүсийн оролцоог хангах. Хүмүүсийн дундаа жендерийн, малчдын, залуучуудын зэрэг тэр болгон оролцоог нь дэмжээд байж чаддаггүй, оролцоо нь хангалтгүй байдаг бүлгүүдийг оролцуулах үндсэн зорилго хүлээгдэж буй үр дүн гэж бол ойлгож болно.

3-д мэдээж үндэсний үйлдвэрлэгчдээ тодорхой хэмжээнд дэмжиж .../минут дуусав/

Б.Уянга: Микрофон сунгаад өгөөрэй. Индрийн микрофон.

Ж.Санчир: Нэг иймэрхүү явж байгаа. Арга хэмжээ маань 8 дугаар сарын 17-28-нд болохоор төлөвлөгдөөд, манай ажлын алба бусад холбогдох яам газруудтайгаа холбогдоод зохион байгуулалтын ажлаа хангаад явж байгаа. Шат бүрээр нь. Тэгэхээр ерөнхий ойлголт өгөхийн тулд 8 сарын 17-21-нд бол албан ёсны нээлт, конвенцын хүрэн дэх албан хэлэлцээ зэрэг багтсан хамтын ажиллагааны 7 хоног багтаж байгаа. Үүний дараа 1 хоног албан ёсоор амраад, дараа нь High level meetings буюу төрийн тэргүүдийн чуулга уулзалт 23-нд болоод, 24-нд thematic day буюу сэдэвчилсэн 4 өдөр дараалаад явахаар үргэлжилж байгаа. Энэ хүрээнд санхүүжилтийн өдөр буюу манай улс орнуудын Сангийн сайд нар бусад холбогдох албан тушаалтнууд хөрөнгө оруулалтын сан зэрэг бусад холбогдох байгууллагууд, хувь хүмүүс зэрэг оролцоод явах ийм өдөр байгаа. 8 сарын 25-нд Усны өдөр. Түрүүн ярьсанчлан асуудлууд хөндөгдөөд явна. Газар ба хүний өдөр 8 сарын 27-нд хүнсний систем ба хөрсний эрүүл мэнд гээд сэдэвчилсэн өдрүүд маань дуусаж байгаа.

Тэгэхээр ерөнхий бүдүүвчээр нь дүр зургаар нь харах юм бол хурал иймэрхүү үргэлжлэх сэдэвтэй байгаа. Тэгээд шууд асуулт хариултад хариулаад явчихъя гэж бодож байна. Баярлалаа.

Б.Уянга: Санчир ахлагчид баярлалаа. Тэгээд өнөөдрийн дэд хорооны хуралд хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Батчулууны Бат-Өлзий Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Түвдэндоржийн Балжинням Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөц, зохистой ашиглалтын бодлогын газрын дарга, Нямхорлоогийн Өнөр COP17 бага хурлын зохион байгуулах ажлын

албаны Үйлчилгээ, логистик, аюулгүй байдлын газрын дарга. Тэгээд Санчир дарга сая танилцуулгаа хийлээ.

Тэгээд бид нар яг энэ танилцуулгатай холбоотой асуултаа одоо асуугаад хариултаа аваад явахаар байна уу. Эсвэл дараагийнхаа мэдээллийг сонсохоор байна уу. Дараагийнхаа мэдээллийг болохоор Өнөр дарга танилцуулна. Тэгээд та ер нь хүлээгдэж байгаа үр дүн дээрээ Улсын Их Хурлын гишүүдээс, Их Хурлын зүгээс авах дэмжлэгээ ерөнхийд нь базаад танилцуулаад өгөөрэй.

Н.Өнөр: Сайн байцгаана уу эрхэм гишүүд ээ. Энд хуран цугласан та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. СОР 17 Зохион байгуулах ажлын албаны Үйлчилгээ, логистик хариуцсан газрын дарга Өнөр байна. Та бүхэнд өчигдөр бид хэд бас Үндэсний хорооны 16 дугаар хурлаар танилцуулсан танилцуулгыг товчхон танилцуулъя. Бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулалтын хувьд хэрхэн үр дүнтэй ажиллаж байна. Юу хүлээгдэж байна гэдэг тухай танилцуулъя.

Ерөнхийдөө СОР 17 зохион байгуулах Үндэсний хороо маань 12 дэд хороотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь бол Бодлого төлөвлөлт хариуцсан дэд хороо, Аюулгүй байдлын дэд хороо, Өндөр дээд түвшний арга хэмжээ хариуцсан дэд хороо, Барилга байгууламж хариуцсан дэд хороо, Зам, тээвэр логистикийн дэд хороо, Харилцаа холбооны дэд хороо, Хоол үйлчилгээ хангамж, эрүүл ахуй хариуцсан дэд хороо, Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан дэд хороо, Соёл, аялал жуулчлалын хөтөлбөр, Зочид буудал хариуцсан дэд хороо, Визний асуудал хариуцсан дэд хороо, Хамтын ажиллагаа хариуцсан дэд хороо, Ногоон бүс хариуцсан дэд хороо гэсэн ийм 12 дэд хороог тус бүр сайд нар Засгийн газрын гишүүд, тухайлсан яамны Төрийн нарийн бичгийн даргаар удирдуулаад үйл ажиллагаа явж байна. Үүний дараагаар ажлын алба нийтдээ 40 хүний бүрэлдэхүүнтэй 2026 онд ажиллахаар бүтцийн хувьд бол батлагдсан. Ажлын албаны бүтцийг товчхон танилцуулахад ажлын албаны дарга, түүний доор 3 газар буюу бодлого хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах газар, үйл ажиллагаа, логистик, аюулгүй байдал хариуцсан газар, менежмент зохион байгуулалтын газар гэсэн 3 газартай, хуулийн багтайгаар үйл ажиллагаа явуулаад, 12 дэд хороодод дэмжлэг үзүүлэн координаторын зохион байгуулалтын ажлыг бол гүйцэтгээд явж байна.

Ажлын алба үндэсний хорооны нийт 786 ажил бүхий нарийвчилсан календарьчилсан төлөвлөгөөг бол Үндэсний хорооны хурлаар батлагдсан. Үүнд бол ажлын явцыг та бүхэнд танилцуулахад бол нийтдээ бид яаж үнэлсэн бэ гэхээр төлөвлөгөөг 30 хувь гэж үнэлээд, гүйцэтгэлийг 70 хувь гэж үнэлсэн байгаа. Төлөвлөгөө албажсан учраас 100 хувийн биелэлттэй. Ажлын гүйцэтгэл бол 37 хувийн гүйцэтгэлтэй, нийт гүйцэтгэлийн 70 хувьтай харьцуулаад манай ажил бол 55,9 хувийн явцтай явж байгаа юм.

Ерөнхийдөө ингээд систем ашиглаад бодит цагийн горимоор холбогдох албан тушаалтнууд бол байнгын хяналт тавиад, аль ажлууд хийгдэж байна, аль ажлууд хоцрогдолтой байна, алин дээр дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна вэ гэдгийг тухай бүр нь хараад явах боломжтой байдаг.

Дараа нь бол барилга байгууламжийн хувьд 44м² бүхий түр барилга байгууламжийг Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн зүүн талд одоо СОР 17-ийн хурал хийхэд зориулсан ийм түр бүтээн байгуулалтыг бол хийж байгаа. Энэ бол сонгон шалгаруулалтаар гүйцэтгэгч компани шалгараад, нийслэлээс хариуцаад барилгын

ажлыг бол 5 дугаар сарын 1-нд эхлэхээр дэд бүтцийн ажлыг бол 100 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэсэн байна.

Цэцэрлэгт хүрээлэнгийн зүүн талд байрлах энэ бүсэд бол цэнхэр бүс, ногоон бүс гэсэн 2 бүс байх юм. Цэнхэр бүсэд маань бол яг хурлын үндсэн үйл ажиллагаа явагдаад, энэ бүс маань бол тухайн үеүдэд НҮБ-ын тусгай хамгаалалтад орох элчин сайдуудын яамд шиг тухайн газар бол олон улсын газраар ингээд хамгаалалтад ороод явна. Түүний наана та бүхний харж байгаа ногоонтой жижиг хэсэг бол ногоон бүс буюу Монгол Улсын Засгийн газрын хариуцан зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, соёлын хөтөлбөрүүд, иргэний нийгмийн төлөөллүүд, олон улсын байгууллагууд, малчид, иргэд ирж хэлэлцүүлэгт орох, яг энэ цөлжилттэй тэмцсэн энэ хурлын санаачилгын хүрээнд өөрсдийнхөө санаачилгыг нэгдсэн байдлаар дэвшүүлэх ийм үйл ажиллагаа явагдах юм байгаа юм. Тэгэхээр зэрэг бид бол хамтын ажиллагааг сайн дурынхныг татан оролцуулж энд ажиллуулах, НҮБ-аас сертификат олгох, тэдгээр хүүхдүүдэд сертификат олгох тал дээр бол ажиллаж байна. Иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэд шинжээчид, судлаачдаа бол бүгдийг нь хамруулаад ингээд оролцоод явах нэгдсэн бодлогыг баримтлаад ажиллаж байгаа. Энэ бол ерөнхий зураглал байна. Ногоон бүс рүү ордог хаалганы иймэрхүү байдалтайгаар төлөвлөөд явж байгаа.

Дараагийн асуудал бол мэдээж хэрэг зам тээвэр, логистикийн асуудал бол хүндээр тусна. Улаанбаатар хот бол нэлээн замын түгжрэлтэй байдаг. Үүн дээр нэмэгдээд жуулчны сезон дээр олон зочид төлөөлөгчид ирэхээр энийг хэрхэн зохион байгуулах вэ гээд Зам, тээврийн дэд хороо бол маш сайн ажиллаж байгаа. Энэ дээр бол нийтдээ зочид буудлуудтайгаа, хурлын бүстэйгээ, нисэх онгоцны буудал, олон улсын галт тэрэгнийхээ буудалтай уялдуулаад чиглэлүүдийг гаргаад, маршрутыг, автобуснуудыг гаргаад явж байна.

Зочид буудал хариуцсан дэд хороо болбол бас ажлаа сайн хийж байгаа. Энд бол 85 зочид буудлыг одоогийн байдлаар зочдыг буулгана гэсэн төлөвлөлтийн дагуу эхний ээлжид 30 гаруй зочид буудлуудтай гэрээг нь хийчихсэн. Төлөвлөгөөний дагуу бол хүрэлцээгүй болох юм бол хэрхэн тэлж ажиллах вэ гэдэг төлөвлөгөөг танилцуулсан. Ингээд ажиллаад явж байна. Ерөнхийдөө энэ зочид буудлууд бол Улаанбаатар хотын А бүсэд голцуу байна. Хэрэвзээ дахин зочид буудлуудын тоог, өрөөг нэмэх шаардлага гарах юм бол тэлэлт хийгээд Б бүс рүү хэрэвзээ бүр үнэхээр болохгүй бол Горхи Тэрэлж рүү тэлэлт хийнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй. Энийг бол нөөц төлөвлөгөө гэж үзээд, зочид буудлын тээвэр логистикийн асуудлыг мөн шийдэхээр ажиллаж байна.

Аюулгүй байдлын дэд хороо бол нийт 12 дэд ажлын хэсэг байгуулсан. НҮБ-ын Аюулгүй газартай бол нягт хамтарч ажиллаж байна. Тусгай сургалтуудыг хийгээд эхэлчихсэн, бэлтгэл хангаад эхэлчихсэн. Нэгдсэн марш тактикийн сургалтаа 5 дугаар сарын 25-нд эхлүүлэхээр ажиллаж байна.

Визний асуудал хариуцсан дэд хороо болохоор цахим нэгдсэн веб хуудас нээгээд, үүгээрээ бол НҮБ-ын бүртгэлийн энтиго системтэй хэрхэн уялдаж ажиллах вэ. Зочдод түргэн шуурхай и-визийг хэрхэн олгох тал дээр бол зөвшилцөөд, ажиллаад явж байна.

Хоол хүнсний дэд хороо бол мөн 9 ажлын хэсэг байгуулчихсан. Зочдод таарсан меню бэлтгэх, тухайн бүсэд ажиллаж байгаа ажилчдад А хоол бэлтгэх, шашин шүтлэгийг нь хүндлэх, эрүүл мэндийн тусгай хэрэгцээг хангасан байдлаар хоол

тэжээлийн шим тэжээлийг бас анхаарч үзээд энэ дээр бол менюгээ гаргаад ажиллаад явж байна.

Дэд хороодын ажлын явцыг товчхон танилцуулахад бол ийм байна. Тэгэхээр та бүхнээс бид юу хүсэж байна гэхээр би Үйл ажиллагаа хариуцсан газрын даргын хувиар ярьж байгаа гэдгийг бас та бүхэн минь ойлгоорой. Бид бол Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын талуудын 17 дугаар бага хурлыг Монгол Улсад Улаанбаатар хотод бол зохион байгуулахаар байгаа. Зүгээр энэ хурал нь бол зөвхөн дан ганц хурал гэдэг утгаараа биш том утгаараа бол Монгол Улсыг олон улсын анхааралд оруулах, үүнтэй уялдуулаад хүлээн авагч улс гэдэг давуу байдлаараа бол олон улсын төслүүдийг Монгол Улсдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар бас нөлөөтэй байдлаар оролцох болов уу гэсэн хүлээлттэй байна. Одоо Road to one billion буюу 1 тэрбум доллар босгоно зорилттой байгаа. Тэгэхдээ зөвхөн COP 17-ийн хүрээнд биш нийтдээ. Тэгэхээр энд хэрхэн бид нар уялдаа холбоотой ажиллаад, нөлөөлөлтэй оролцох вэ гэхээр яг л хурлын үеэр болж байгаа төслүүд, хөтөлбөрүүд, хэлэлцээрүүд амжилттай явагдаад, тэгсний дараагаар болбол одоо хаана ямар төсөл хөтөлбөрийг аль улс хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг шийдвэр нь гарах байх. Зүгээр бидний хувьд бол тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулаад SDG 8, т SDG 11, SDG 17 эдгээр том томоохон тогтвортой хөгжлийн зорилтуудтай бол яг манай 3 үндсэн санаачилга бол нягт уялдаад явж байгаа. Эдийн засгийн өсөлт, зохистой хөдөлмөр эрхлэлт нь бол аялал жуулчлал үйлчилгээний салбарын өсөлт болон эдийн засгийн идэвхжилтийг нэмэгдүүлэхээр харагдаж байна. Тогтвортой хот орон нутаг SDG 11-ийн хүрээнд бол үүнийгээ дагаад олон улсын стандартыг хангасан арга хэмжээний орчныг бүрдүүлээд явахад чиглэж байна.

SDG 17 буюу хөгжлийн төлөөх түншлэлд бол олон улсын түншлэл, хамтын ажиллагаа дипломат харилцааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэж бид итгэж найдаж байна. Иймээс та бүхнийг дэмжин ажиллахыг хүсье. Баярлалаа.

Б.Уянга: Өнөр даргад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Пунсалмаа гишүүнээр тасалъя. Ундраа гишүүнээр эхлэх нь байна.

А.Ундраа: Мэдээлэл хуваалцсан албан тушаалтнуудад талархлаа. Энэ хүрэх үр дүнгийн талаар өнөөдөр манай дэд хороо илүү анхаарч уулзъя гэж байгаа. Энэ хугацаанд бол хүрэх үр дүн яах вэ, логистикийн асуудал зохион байгуулалтын асуудлууд бол явцаа ингээд хэмжиж байгаа нь бол сайн байна. Хүрэх үр дүнг бол миний ойлгож авснаар бол саяын танилцуулгуудаар илүү мөнгөн юм уу, төчнөөн долларын хэмжээтэй санхүүжилтийг босгож чадлаа. Коммитмент авлаа, ийм зар хийгдлээ гэдгээр ингээд амжилттай хэмжих гэж байгаа юм байна. Тийм үү. Тэгэхээр энэ нь нийтдээ төчнөөн оролцогчоос ийм хэсэг нь Засгийн газрын зүгээс, ийм хэсэг нь хувийн хөрөнгө оруулалтын сан, ОУБ-ын зүгээс гэж ингэж төсөөлж байгаа гэж хуваагаад, тэр стратеги арай жоохон нарийсгасан тийм төлөвлөлт байна уу. Энийг 1 дүгээрт тодруулмаар байна.

2 дугаарт бизнесийн уулзалтуудыг энэ цаглавар дээрээс харахад бол нөгөө би Business For Land билүү тийм партнершипийн хүрээнд хийж байгаа гэж ойлгосон. Тэгэхээр энэ хүрээндээ нийтдээ хэчнээн хувийн секторын оролцогч ирнэ гэж төсөөлж байгаа вэ.

Цөлжилттэй холбоотой асуудал гэж байгаа учраас бас мэдээж энэ усны менежменттэй нэгтгэж, ялангуяа цөлжилт бол энэ усны нөөц багасах эсвэл усны

нөөцийн зохисгүй ашиглалт юм уу, хүний хүчин зүйл эсвэл байгалийн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хуурайшиж байгаа агаарын температур нь нэмэгдэж, илүү дулаарч байгаа, зарим тохиолдолд хүйтэн, эрс тэс болж байгаа энэ байгалийн экстрим үзэгдлийн давтамж нэмэгдэж байгаа гээд эдгээр үзэгдлүүдтэй бол холбоотой гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ бол бас 1 улс дангаараа шийдэж чадах ажил биш учраас ийм олон улсын хамтын ажиллагаа маш чухал. Тэгээд тэр хүрээндээ бол олон улсын гэрээ конвенцуудын хэрэгжилтийг хэрхэн авч үзэх гэж байна. Тэр дээр бас хууль тогтоогчдын зүгээс бидний зүгээс ямар байдлаар оролцвол манай Монгол Улсын урдаа тавьсан зорилгод илүү хэрэгтэй байхаар байна. Тухайлж хэлэх юм бол жишээлэхэд, Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдийн бүлгийн зүгээс нийт оролцож байгаа бусад улсын хууль тогтоогчид эмэгтэй парламентчийг хүлээж авах ийм яриа хэлэлцээр өрнүүлэх нь зохистой гэж харж байна. Бас эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй, амьжиргаатай холбоотой ялангуяа усны хомсдолтой холбоотойгоор, ялангуяа хуурай ган гачигтай нутгийн ард иргэдийн амьжиргаа тэр дундаа тухайн өрхийн эмэгтэйчүүдийн аж байдалд бол маш их хүчтэй нөлөө үзүүлдэг нь бол судалгаагаар тогтоогдсон зүйл. Энийг бол авч үзэж хэрхэн дасан зохицож сөрөн тэсвэрлэх вэ ийм ажиндаа гаргах чиглэлээр бид бас хийж болж байна. Тэгээд тодруулъя.

Б.Уянга: Хэн хариулах вэ. Санчир ахлагч уу.

Ж.Санчир: Ундраа гишүүний асуултад хариулъя. Эхнийх асуулттай холбоотой гэвэл ерөнхий 1 тэрбум доллар гээд түрүүн дурдагдсан. Тэр бол та яг зөв тайлбарлалаа. Зөвхөн мөнгөн болон мөнгөн бус амлалтууд, коммитментууд зэргийг бид нар ерөнхийдөө нэгтгээд, өмнө нь болсон COP 16 хурлаас тодорхой хэмжээний одоо багцаа аваад, тодорхой хэмжээнд багасгаад тавьсан тоо байгаа. Тэгэхээр тэр хүрээнд бол бид нар яг тэдийг тэр хэмжээгээр босгоно гэсэн нарийн тооцоолол, төсөөлөл бол одоогийн байдлаар алга байна. Ерөнхийдөө бол өнгөрсөн жил Байгаль орчны сайд, дэд сайд, бусад албан тушаалтнуудын гадаадад ажиллаж, томилолтоор яваад тодорхой хэмжээний яриа хэлэлцээрүүд хийгээд явсан. Яг амлалтын өмнөх тодорхой хэмжээний ярьсан ярианууд бол байгаа. Олон улсын хөгжлийн банкнууд, хөрөнгө оруулалтын сангууд зэрэг байгууллагууд хүмүүстэй яриад явж байгаа. Тэгэхээр яг тэрийг бол одоогийн байдлаар төсөөлөлдөө ороод 1 тэрбум гэж байлаа гэж бодоход тэрийг тэдэн тэд гэж ярихад бол жоохон хүндрэлтэй байгаад байгаа.

2 дугаарт бизнесийн байгууллагуудтай манай ажлын алба ерөнхийдөө бүтцийн тодорхой хэмжээнд өөрчлөлтөд ороод, дахин зохион байгуулагдаад, өнгөрсөн сард эхний уулзалтаа зохион байгуулсан байгаа. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж үйлдвэрийн танхимуудын төлөөллийг дуудаад, иймэрхүү, иймэрхүү хэмжээний санаачилга явж байна. Хурлын үндсэн санаачилгуудын хүрээнд мөн яг хурлыг зохион байгуулах хүрээнд санхүүжилтийн нөхцөл байдал ийм байна. Энэ тал дээр ингэж, ингэж хамтарч ажиллая гэсэн уулзалтууд хийгээд явчихсан байгаа. Тэгэхээр ерөнхийдөө бол ойрын ирээдүйд Business for COP гэдэг маягийн уриа дор зөвхөн аж үйлдвэрийн танхимууд биш бусад бизнесийн төлөөллүүдтэйгээ уулзаад, илүү нарийвчилан яриад явах бол ийм төлөвлөгөө бол байгаа.

3 дугаар асуудал усны асуудал манай яамны төлөөлөл Балжинням дарга хариулах байх гэж бодож байна.

Эмэгтэйчүүдийн амьжиргаа, тогтвортой хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудал бол манай хамтын ажиллагааны багийн асуудал болоод явчхаж байгаа.

Тэгэхээр тэр дээр бол бүх санал санаачилгууд нээлттэй. Ундраа гишүүн албан ёсоор саналаа тавиад, иймэрхүү, иймэрхүү боломж байна. Ийм ийм хүмүүс урих боломжтой байна гэдгийг бол бүрэн нээлттэй гэж бодож байгаа. Тэгээд манай ногоон бүс буюу түрүүн Өнөр даргын ярьсан. Ногоон бүсийн павильонуудын асуудал шийдэгдээд зар нь гараад явсны дараа илүү тодорхой саналууд тавиад, тэрийгээ цааш нь хэрэгжүүлээд явах боломжтой болох байх. Тэгэхгүй яг өнөөдрийн байдлаар явах гэхээр павильонуудын асуудал тодорхой хэмжээнд тодорхой болоогүй байгаа учир шууд тэрэнд тэгж бүртгүүлээч ээ гээд яриад явахад бол жоохон эрт байгаа. Тэгэхдээ санал санаачилгын хүрээнд бол.../минут дуусав/

Б.Уянга: Нэмээд хариулах уу. Болсон юм уу. Тодруулах уу? Балжинням дарга хариулах юм байна.

Т.Балжинням: Эрхэм Улсын Их Хурлын гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд Ундраа гишүүний асуултад хариулъя. СОР-ын хүрээнд 8 сарын 25-ны өдөр бол усны өдрийг Монгол Улсын Засгийн газраас санаачилгыг бол дэвшүүлж байгаа. Тэгээд мэдээж Монгол улсад усны нөөцийн хомсдол үүссэн нөхцөлүүд байгаа. Говийн бүсэд бас усны асуудал хүндрэлтэй байгаа. Тэгээд Монгол Улсын Засгийн газар буюу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам усны хувьд бол хэд хэдэн мега төслүүдийн хүрээнд хэрэгжүүлж байгаа.

Говь руу ус татах Онги Орхон голын мөн Хэрлэн тооны асуудлуудын хүрээнд мөн Эгийн голтой холбоотой асуудлуудын хүрээнд төслүүд хэрэгжиж байгаа. Тэгээд Монгол Улсын Засгийн газар буюу Усны агентлаг нь нийлээд 333 сумд бол хөг цөөрөм байгуулах асуудлуудыг бас дэвшүүлээд ажиллаж байгаа. Тэгээд усны .../минут дуусав/

Б.Уянга: Минут нэмээд өгье.

Т.Балжинням: Баярлалаа. Усны менежментийн төлөвлөгөөнийхөө хүрээнд далайд гарцгүй орнууд буюу Евроазийн орнуудтай бол бид нар энэ усны асуудлуудын хүрээнд асуудлуудыг дэвшүүлээд ингээд явж байгаа. Мөн ус ба газрын нэгдсэн менежментийн санаачилга гэдэг дээр бас төлөвлөн ингээд ажиллаж байна. Мөн байгальд суурилсан шийдлүүд буюу дэд бүтэц дээрээ бол энэ усны асуудлуудыг бас шийдвэрлэх асуудлуудыг бол төлөвлөн бид нар ажиллаж байна.

Мэдээж жендертэй холбоотой хүрээнд усыг гантай бүс энэ дэлхийн хэмжээнд усны хомсдол ялангуяа эмэгтэй хүн нь жендерийн асуудлын хүрээнд усыг олон километрээр тээвэрлэдэг энэ асуудлуудын хүрээнд бол энэ асуудлуудыг бас ингээд тавьж байгаа.

Монгол Улс энэ усны нөөцтэй холбоотой асуудлуудын хүрээнд бусад орнуудтай гангийн асуудлуудын хүрээнд өмнөх СОР дээр санаачилга гарч байсан улсууд .../минут дуусав/

Б.Уянга: Минутыг нь 2, 3 минутаар өгөх боломж байхгүй юу. Яг тодорхой хариулахгүй бол.

Т.Балжинням: Дэвшүүлэн ингээд ажиллаж байна. Товч мэдээллээ.

Б.Уянга: Тодруулах уу Ундраа гишүүн.

А.Ундраа: Нэгэнт бас цаана нь улс орны нэр хүнд байна. Тэгээд энэ олон хүний хүч хөдөлмөр байна. Тийм учраас бас аль болох үр дүнтэй, амжилттай зохион байгуулаасай гэж хүссэн үүднээс ингэж асууж байгаа. Тэгээд энэ дээр бол өмнө нь бас 2, 3 өөр уулзалтууд хийхэд энэ дотоод холбоо харилцаа сул байгаа юм уу гэсэн ийм сэтгэгдэл надад бол төрсөн. Тэгэхээр бас би буруу ойлгосон ч байж магадгүй юм. Тухайлбал 1 жишээ дурдахад Land installation art-ийг Green zone-д хийе гэхэд тэр талаар Үндэсний цэцэрлэгт хүрээлэн мэдээгүй байх жишээний. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны яам, Соёлын яам хоорондын холбоо харилцаа бол жоохон удаан явж байгаа бас улбаатай байж болох юм. Гэхдээ хариуцсан хүмүүс нь бүгдээрээ мэдээллээ хурдан солилцож байвал одоо энэ чинь хэдхэн хоногийн дараа болох гэж байгаа учраас энэ харилцаа холбоо маш их сайн байх хэрэгтэй байна. Энэ талаар яаж ажиллаж байгаа механизмаа тайлбарлаадах уу. Хэр давтамжтай уулздаг юм. Хэн зангидаж .../минут дуусав/

Б.Уянга: Өнөр дарга.

Н.Өнөр: Ундраа гишүүний асуултад хариулъя. Координацыг бол Үндэсний хорооны ажлын алба хариуцаад ажиллаж байгаа. 12 дэд хороогоо дэмжиж ажилладаг гэдэг утгаараа. Ерөнхийдөө бол Үндэсний хороо бол сард 1 удаа хуралддаг. Шаардлагатай үед бол ээлжит бус хуралдаануудыг хийдэг. Дэд хороод бол бас сардаа 1 хуралдаад явдаг. Дэд ажлын хэсгүүд гээд байгуулагдчихсан байгаа. Ерөнхийдөө бол таны хэлж байгаатай ерөнхийдөө санал нэг байна. Сардаа 1 удаа бас уулзаагүй дэд хороод байгаа. Одоо бол ажлыг эрчимжүүлэх хүрээнд дэд ажлын хэсгүүд гаргачихсан. Тэдгээр нь бол одоо бүр 7 хоног бүр уулзаад явъя гэсэн ийм механизмаар эрчимжүүлж ажиллах гээд ингээд явж байгаа.

Б.Уянга: Ойлголоо. Ундраа гишүүн тодруулъя.

А.Ундраа: Сая бас нөгөө эмэгтэй гишүүдийн санаачилгыг бол хэллээ. Тэгэхээр энэ санал санаачилгыг хүнд хүргүүлье, бичгээр хүргүүлье гэвэл хэнд хүргүүлэх ёстой вэ. Энэ бол хэнд, хаана хандах нь тодорхой баймаар байна. Сошиал медиагаар явж байгаа та бүхний ажилтай холбоотой юмыг харахаар жишээлбэл залуучуудын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах, тэрний зар, бүртгэлийн мэдээлэл явж байгаа нь харагдсан. Энэ сайн хэрэг. Тэгээд тэр нь зөвхөн Монгол хэл дээр бас биш англи хэл дээр бусад хөрш орнууд руу болон харилцагч орнууд руугаа мэдээллийг хуваалцаж байгаа байх гэж найдаж байна. Тэгэхээр хэнд энэ талын мэдээллийг хүргүүлэх вэ. Бас Ногоон намын зүгээс улс төрийн намуудын оролцоог хангах, улс төрийн намууд оролцож байвал бусад улс орнуудын улс төрийн намуудтай яриа хэлэлцээрийг өрнүүлэх, дараа дараагийн хууль тогтоомж төсөвт суулгах зэрэг ажил дээр бид хэрхэн улс орныхоо төлөө лоббидож болох вэ гэсэн зарчмыг хариулах уу.

Б.Уянга: Индрийн микрофоныг өгье.

Б.Бат-Өлзий: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Бат-Өлзий хариулъя. Ундраа гишүүний асуултад хариулъя. Албан ёсоор хүсэлтийг бол Үндэсний хорооны дарга бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад албан ёсоор хаяглах нь зүйтэй. Үүнээс бол ажлын алба болон манай яамны хариуцсан албан тушаалтнуудад цохогдоод ингээд явдаг. Үүний дагуу бол албан ёсны ажлууд ингээд хийгдээд явдаг.

Бас нэмэлт мэдээлэл өгөхөд COP 17-ийн албан ёсны веб сайт unccd.cop17.org гэдэг сайт өнөө маргаашгүй нээгдэх гэж байгаа. Мэдээллүүдийг өнөөдөр бид нар бас хамтран шалгаж байна. Бүх мэдээллүүд нэгтгэгдээд, шалгасны дараа, нээсний дараа бол тэр сайт дээр ямар арга хэмжээнд яаж оролцох, яаж бүртгүүлэх гэдэг бүх мэдээллүүд нэгдсэн байдлаар веб сайт дээр харагдах юм. Баярлалаа.

Б.Уянга: Баярлалаа. Пунсалмаа гишүүн.

Б.Пунсалмаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Цөлжилттэй тэмцэх нэгдсэн үндэсний байгууллагын конвенцын тогтвортой хөгжлийн хүрээнд COP 17 энэ том хурал Монгол Улсад зохион байгуулагдах гэж байгаа нь маш чухал үйл ажиллагаа. Үүгээр болбол 10 мянга орчим талуудын оролцоо Монгол Улсад ирэх нь. Тэгээд Монгол Улсын зүгээс тал хээрийн төлөвлөгөө дэвшүүлээд, 1 тэрбум ам.долларын санхүүжилт босгох ийм төлөвлөгөөтэй байгаа юм байна. Тэгэхээр энэ төлөвлөгөөний ер нь нарийвчилсан ийм алхмууд нь гарсан уу.

Би түрүү жил Узбекистанд бас энэ COP 17-ийн үед айлчлалаар очиж байсан. Тэгээд энэ бол маш том арга хэмжээ юм байна лээ. Олон хотуудад хуваагдаж, олон том уулзалтууд зохион байгуулагдаж байна лээ. Тэгээд Узбекистанаас 1 олж мэдсэн нь цөлжилт нь бас манай Монгол шиг нэлээн их явагдчихсан. Цөлжилтийг бууруулах бас ийм усжуулалтын, сувагжуулалтын нэлээн олон ийм хөтөлбөрүүд хэрэгжүүлээд, хөдөө аж ахуйн салбараа сайжруулаад ийм том өөрчлөлтүүд хийсэн юм байна. Тэгэхээр та бүгдийн энэ тал хээрийн төлөвлөгөө гэдэг бол их зөв төлөвлөгөө байна. Үүний нарийвчилсан төлөвлөгөө нь Монгол Улсын газар нутгийн хувьд 40 хувийн цөлжилтийг бууруулах ер нь ямар нарийвчилсан төлөвлөгөө гаргасан юм бол гэж ингэж бодож байна.

Хэдий хэмжээгээр бид нар төлөвлөгөөгөө сайн нарийвчилж гаргана төдий хэмжээгээрээ олон улсын байгууллагаас бид нар амжилттай, үр дүнтэй ажиллах ийм бололцоо нээгдэх байх гэж бодож байна.

2 дугаарт нь энэ олон талуудын оролцоотой ийм томоохон арга хэмжээ зохион байгуулахад Монгол Улсын хувьд тэр дотроо энэ Улаанбаатар хотын түгжрэл бөглөрлийн хүрээнд энэ логистикийн асуудлыг бид нар маш зөв зохион байгуулах хэрэгтэй. Энэ бол энэ хурал уулзалтын үр дүнд их нөлөөлдөг ийм зүйл юм байна лээ гээд бас бусад хурлуудаас олж ажигласан зүйлээ хэлье гэж бодож байна. Тэгээд энэ 2 асуулт дээр хариулт авъя.

Б.Уянга: Хэн хариулах вэ. Санчир ахлагч. Индрийн микрофоныг өгье.

Ж.Санчир: Түрүүн миний дурдсанаар тал хээрийн санаачилга маань 3 тэргүүлэх санаачилгаас бүрдэж байгаа. Тал хээрийн төлөвлөгөө маань. Энэ бүрийн хүрээнд эхний бэлчээрийн санаачилгатай маань холбоотой НҮБ-ын Цөлжилтийн конвенцын нарийн бичгийн газрын даргатай хамтарсан concept note буюу төслийн урьдчилсан баримт бичгүүд гарч байгаа. Тэгэхээр бид хэд бол үзэл баримтлал гэж бол буулгаад байгаа. Тэгэхээр үзэл баримтлал гэдэг маань ерөнхийдөө юу вэ гэхээр ийм ийм асуудлыг шийдэх гэж байгаа, энэ дээр ингэж ингэж оролцох боломжтой гэдэг асуудлыг ерөнхийд нь тайлбарласан ийм бичиг баримт. Тэгэхээр үлдсэн 2 санаачилгад маань бас иймэрхүү 2 concept note боловсрогдоод явж байгаа. Удахгүй эцэслэнэ гэсэн төлөвлөгөөтэй.

Тэгэхээр үүнээс цааш манай бодлого, төлөвлөлтийн баг юун дээр ажиллаж байгаа вэ гэвэл энэ 3 санаачилгынхаа хүрээнд 1 дүгээрт Монгол Улсад маань өнөөг хүртэл ямар ямар төсөл хөтөлбөр хэрэгжсэн бэ, үр дүн нь юу байв. Маш сайн туршилтын кэйсүүд юу байна. Өргөжүүлээд санхүүжилт татаад явж болохоор, орхигдоод буй асуудлууд юу байна гэсэн байдлаар илүү зураглал гаргах байдлаар ерөнхий бас давхар ажиллаад явж байгаа. Тэгэхээр энэ нь юунд хэрэгтэй вэ гэхээр Дэлхийн банк ч гэдэг юм уу, олон улсын түншүүдтэйгээ уулзахад манай талд бол ийм боломж болон бас нөхөх ийм хэрэгцээ байгаад байна. Та хэд маань санхүү болон бусад төслийн техникийн тусламжаар ямар нэгэн байдлаар ингэж оролцох боломжтой юм шүү гэдэг ийм тал талаасаа уулзах ийм боломжийг нээж өгөх гэсэн чиглэл рүү ажиллаж байгаа гэж хэлж болно.

Тэгэхээр миний тайлбарласнаар бэлчээрийн санаачилга бол UNCCD-тэй хамтраад концепцууд нь боловсруулагдаж байгаа. Нөгөө 2 санаачилга маань одоо боловсруулагдаад явж байгаа. Үндэсний санаачилга маань. Тэгэхдээ түрүүн миний тайлбарласнаар Монгол Улс манлайлж буй боловч бас олон улсын санаачилга гэж явж байгаа. Тэгэхээр Монгол Улсын бас зөвхөн асуудлууд биш, манайхтай ойр нөхцөлтэй Төв Азийн ба мөн далайгаас алслагдсан ийм улсууд ижил эрх ашигтай, ижил сонирхолтой байгаа үүднээс тэр хэмжээнд уулзалтуудыг хурлын үеэр зохион байгуулж, урьдчилсан тохиролцоонд хүрч, бусад арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр зориод явж байгаа гэсэн үг.

Б.Уянга: Ойлголоо Пунсалмаа гишүүн тодруулах уу.

Б.Пунсалмаа: Энэ бэлчээрийн санаачилга гээд энэ төслийн урьдчилгаа баримт бичиг гарсан байгаа гэж байна. Энийг бичгээр авахыг хүсэж байна. Тэгээд газар нутгийн хувьд 40 хувийн доройтол биологийн уур амьсгалын сөрөг нөлөөлөл үзүүлчихсэн байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ бэлчээрийн санаачилга маань энэ 40 хувийн доройтлыг арилгах бүрэн дүүрэн төлөвлөгөө байж чадах уу. Тэгээд нөгөө 2 төлөвлөгөөнийх нь талаар ер нь нарийвчилсан энэ төлөвлөгөө энэ алхмуудын талаар бичгээр бид нар бас авъя гэж бодож байна.

Б.Уянга: Батбаяр дарга хариулах уу. Индрийн микрофон.

Ш.Батбаяр: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батбаяр. Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Үндсэн 3 санаачилга маань доороо бас олон төслүүдэд хуваагдана. Төслүүдээ бид бага хурлын үеэр талуудад 197 орон элсэн орсон бага хурлынхаа үеэр хэлэлцүүлж батлуулаад, цаашдаа хэрэгжүүлж ажиллах болно. Төслүүд маань голцуу бүс нутгийн хэмжээний төслүүд байгаа. Зөвхөн Монгол орны газар нутгийг хамарсан биш, одоо ойр орчмын орнуудыг хамруулсан Ази, Номхон далайн орнуудыг хамруулсан төслүүд байх болно.

2 дугаарт 2020 онд хийгдсэн гангийн атласаар манай орны нийт газар нутгийн 72 хувь нь бол цөлжих эрсдэлтэй болсон гэсэн судалгаа гарсан байгаа. Энэ жил энэ атласаа бид нар шинэчлэн батална. Тэгэхээр энэ дээр бас тоо нэлээн өөрчлөлт орох байх. Үүнтэй холбоотойгоор бид бас цөлжилттэй тэмцэх энэ конвенцын талуудын бага хуралд бас их онцгой анхаарал хандуулан ажиллаж төлөвлөгөө баталж байгаа.

Б.Уянга: Баярлалаа. Хэдэн тодруулах асуултауд байна. Өнөөдрийн манай Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны уулзалт бол өчигдөр та хэдийн уулзсан,

яг танай үйл ажиллагааны хурал дээр нарийвчлан танилцуулагдсан мэдээлэл гарсан учраас тэрнээс илүүтэйгээр хүлээгдэж байгаа үр дүн талд нь яаж дэмжиж болох вэ. Яаж тэрийг тогтвортойгоор цааш нь авч явах вэ гэдэг дээр нь мэдээллийг сонсьё гэж төлөвлөж хурлыг зарласан байгаа юм. Тэгэхдээ танай Санчир ахлагч болон Өнөр дарга нарын танилцуулсан мэдээллээс харахад мэдээж хурал удахгүй болох гэж байгаа учраас бэлтгэл ажлын хувьд завгүй байгаа байх. Тэгэхээр сая Ундраа гишүүн болон Пунсалмаа гишүүдийн асуусан энэ бэлчээрийн тэргүүлэх санаачилга, ус ба газрын нэгдсэн менежмент, байгальд суурилсан шийдлийг ингээд 3 багц болгон цогц төлөвлөгөө танилцуулах гэж байгаа гэж ойлголоо. Тэгэхээр энэ 3-тайгаа холбоотой нарийвчилсан мэдээллүүд дээрээ нэлээн сайн суухыг хүсэж байна. Энэ дээр нь ямар нэгэн дэмжлэг хэрэгтэй бол бас хууль тогтоогчдын зүгээс юу байж болохоор байна вэ. Тэрийг бас тодруулаад Батбаяр даргаас асууя.

Бүр тодорхой асуувал тус бүрд нь Монгол Улсаас танилцуулах 1 тэрбум долларыг босгохуйц тэр санхүүжилтийн төлөвлөгөө, төслүүдийн мэдээллийг мэдээж манай талаас гаргаж тавих байх. Тэгээд тэр нь нэгтгэгдээд цогц байдлаар ингээд 3 малгай доор орж ирэх юм байна. Тэгвэл жишээ нь ус ба газрын нэгдсэн менежмент гээд энэ цогц төлөвлөгөө дотор нөгөө бид нарын говийг усжуулах төслүүд орж байгаа юу. Ер нь яг энэ нарийвчилсан төлөвлөгөө нь ТЭЗҮ нь хийгдсэн төслүүд байх ёстой юм уу. Эсвэл юу гэдэг юм хамтарсан БНХАУ-тай эсвэл ОХУ-тай манай хөршүүд юм чинь хамтарсан ийм хил дамнасан төслүүд нь бас концепц байдлаар орж болох юм уу. Тэгэхээр манайд ер нь техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдчихсэн байгаа хэчнээн төслүүд жишээлээд энэ 3 төслийнхөө ус ба газрын нэгдсэн менежмент дээр авч ярих юм бол. Нөгөө Хэрлэн Говь, Орхон-Онги гээд тэр төслүүдийн заримынх нь хэсэгчлээд ТЭЗҮ-үүд нь байгаа шүү дээ. Тэгээд тэд нар орж байгаа эсэхийг тодруулъя.

Хөдөө, орон нутагт томилолт байгаа юу. Үйл ажиллагааны төлөвлөгөө дээр 18-27 байсан уу. Тэр хооронд болох үйл ажиллагаа дээр хөдөө, орон нутагт томилолт байгаа эсэх. Энийг асууя. UNCCD-ийн баримт бичиг гарна гэж ойлгоод байгаа. Энэ хурлын төгсгөлд нь. Тэгээд тэр баримт бичгийн хүрээнд олон улсууд хамтраад, томоохон хэмжээний төслүүд явах юм байна гэж бас ойлголтыг авсан юм. Тэгэхээр энэ хэр бодитой вэ. Баримт бичиг нь үргэлжлэх хугацаатай байдаг уу. UNCCD-ийн баримт бичиг, бодлогын бичиг баримт гарахаар яг дагаад гарах алхмууд нь юу байдаг юм. Эргээд бид нар тайлагнах үүрэг хүлээдэг юм уу. Тайлагнавал хэзээ, хэзээ тайлагнах юм.

Ингээд манай Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо сая Санчир ахлагчийн танилцуулсан танилцуулга дээр тэр тэр зорилгуудтай нь ингээд нийцэж байгаа, ийм ийм хурал гээд танилцуулсан. Тэгэхээр манай Эдийн засгийн байнгын хорооны доор байгаа Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны зүгээс ирэх гэж байгаа, ирэхээр бүртгүүлсэн байгаа улс орнууд руу нэмэлт тийм дэмжих бичгүүд явуулах уу. Эсвэл оролцоод буцсаны дараа, үйл ажиллагааны дараа талархал бас гаргаж явуулах уу. Ямар нэгэн байдлаар хамтын ажиллагааг ямар түвшинд одоогийн байдлаар төлөвлөж байна вэ.

Ш.Батбаяр: Уянга гишүүний асуултад хариулъя. Энэ 3 тэргүүлэх санаачилгынхаа хүрээнд бид доор нь төслүүдийнхээ ерөнхий концептыг гаргасан байгаа. Сая хэлсэнчлэн хурлын үеэр бид санаачилгуудаа танилцуулаад, төслөө дэмжүүлээд, батлуулаад, ТЭЗҮ-ээ хийлгээд явуулна. Ер нь бол бидэнд ТЭЗҮ-тэй төсөл байвал илүү ашигтай. Тэр ч үүднээсээ энэ жил улсын төсөв дээр тусгагдчихсан байгаа Онги төсөл маань одоо явагдаж байгаа.

Хөдөө, орон нутагт томилолт байгаа юу гэж байгаа. Одоогоор яг UNCCD-ийн Нарийн бичгийн даргын газар бүх төлөвлөгөөг баталж шийддэг. Хурлын дараа буюу 29-нд бас хөдөө, орон нутгийн томилолтын ажил яригдаж байгаа. Тэгээд энд эцэслэгдэн батлагдаагүй учраас би бас тодорхой мэдээлэл өгөх боломжгүй юм байна лээ гишүүн ээ. Энэ бүх хурлын холбоотой мэдээ мэдээлэл, төлөвлөгөө, санал санаачилгуудыг UNCCD-ийн нарийн бичгийн газрын дарга нар бидэнд баталж өгдөг байгаа. Одоогоор бол яг тэр орон нутгийн томилолт бол батлагдаагүй байгаа.

Б.Уянга: Ойлголоо энэ UNCCD-ийн баримт бичигтэй холбоотой мэдээлэл бид нарт өгөх хэрэгтэй байна. Хэн хариулах билээ. Батчулууны Бат-Өлзий. Индрийн микрофон.

Б.Бат-Өлзий: Нэмэлт тайлбар өгье UNCCD цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенцын Ерөнхийлөгч тухайн COP хурлаас эхлээд 2 жилийн хугацаатай Ерөнхийлөгчөөр ажилладаг. Тухайн хугацаандаа юу болдог вэ гэхээр COP-оор баталсан санаачилга, дүрэм журам, хамтран баталсан бүх ажлуудыг 2 жилийн хугацаанд хэрэгжүүлэх ажлаа явдаг. Тухайн санаачилга нь хугацаатай юу гэвэл тухайн санаачилга нь өөрөө хэр хугацаанд хэрэгжихээр баталсан тэр хугацаагаараа явдаг. Заавал 1, 2 жил гэдэг хугацаагаар хязгаарлагддаггүй гэсэн үг. Түрүүнд хэлснээр ямар нэгэн Монгол Улсын урт хугацааны бодлого, баримт бичигтэй уялдаж байгаа гэвэл бүх конвенцын баримт бичгүүд Монгол Улсын төлөвлөлттэй урт дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдаж ажилладаг учраас энэ бүгдээрээ уялдаад ажиллана.

Мөн одоо хамтран ажиллах.../минут дуусав/

Б.Уянга: Индрийн микрофоныг өгье.

Б.Бат-Өлзий: Улс орныг урих тал дээр бол албан ёсоор бол Гадаад харилцааны ямаар дамжуулж бүх албан ёсны төрийн төлөөллүүдийг бол урьдаг. Энэ урих асуудал бол Гадаад харилцааны ямаар дамжаад ингээд явж байгаа учраас урих тал дээр бол асуудал байхгүй. Мэдээж Монгол Улсад ирэх үед нь ямар нэгэн байдлаар эмэгтэйчүүдийн талаас ч юм уу та бүхэн саяын хэлж байгаа санал, санаачилга байвал манай ажлын алба болон манай яам руу хүргүүлэхэд бид нар бас хамтран ажиллахад бэлэн байна. Баярлалаа.

Б.Уянга: Ойлголоо. Тэгэхээр ТЭЗҮ-тэй төслүүд орвол сайн. Концепц бас төслийн хамтын ажиллагааны төслийн концепцыг танилцуулж болно гэж ойлголоо. Хөдөө, орон нутагт томилолт байгаа эсэх нь 29-нд яг хурлын дараа байж болно. Одоогоор тодорхой биш юм байна. UNCCD-ийн баримт бичиг нь 2 жилийн хугацаатай гарна. Дотор нь орсон амлалтууд нь урт үргэлжилж болохоор амлалтууд байж болох юм байна. Мэдээж урилгыг бол бид нараар явахгүй. Тэгэхдээ ямар нэгэн байдлаар дэмжлэг хэрвээ энэ дэд хорооноос дэмжиж байна, аа хамтарч ажиллаж байна гэсэн байдал нь та хэдэд хэрэгтэй бол дэмжиж ажиллахад бэлэн байна.

Мэдээлэлтэй холбоотой үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Алга байна.

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурлын бэлтгэл ажил болон хүлээгдэж буй үр дүнтэй холбоотой мэдээлэлтэй танилцаж дууслаа.

Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

14.28 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ